



МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН АРГА ЗҮЙ ЗААВАР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, 3Г-ын II байр
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689
Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:
24.06.2016

ӨӨРЧЛӨЛТ NO: 02
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 09.07.2025

АГУУЛГА

Sl.	Бүлэг	Хуудас
	Агуулга	2
1	Зорилго	3
2	Хамрах хүрээ	3
3.	Нэр томъёо ба тодорхойлолт	3
4.	Үүрэг хариуцлага	4
5.	Хүсэлт гаргагчид тавих шаардлага	4
6.	Итгэмжлэлийн үйл явц	4
	6.1 Итгэмжлэлийн хүсэлт ба үнэлгээний төлөвлөлт	4
	6.2 Үнэлгээний арга зүй	5
	6.3 Үнэлгээний үр дүнг тайлагнах	8
	6.4 Итгэмжлэлийг хадгалах	9
	6.5 Гэрчлэх үнэлгээний нэмэлт зохицуулалт	10
7.	Холбогдох баримт бичиг	11
	ХАВСРАЛТ А: Менежментийн тогтолцооны бүтэц болон тавигдах шаардлагын тодорхойлолт	12
	ХАВСРАЛТ В: ЧМТ (ISO 9001)-ны Гэрчлэх үнэлгээ	13
	ХАВСРАЛТ С: БОМТ (ISO 14001)-ны Гэрчлэх үнэлгээ	17
	ХАВСРАЛТ D: ХАБМТ (ISO 22000)-ны Гэрчлэх үнэлгээ	21
	ХАВСРАЛТ E: ХЭМАБМТ (ISO 45001)-ны Гэрчлэх үнэлгээ	24
	ХАВСРАЛТ F: МАБМТ (ISO/IEC 27001)-ны Гэрчлэх үнэлгээ	29

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 2/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

1 ЗОРИЛГО

Энэхүү арга зүйн зааврын зорилго нь менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын анхдагч итгэмжлэл, магадлах хяналт, давтан итгэмжлэл болон хүрээ өргөтгөх үнэлгээний үед MNAS-ийн үнэлгээний мэргэжилтэн гэрчлэх үнэлгээг сонгох шалгуур, үйл явцыг тодорхойлно. Мөн итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагатай холбоотой гомдлын дагуу болон магадлах хяналтын хүрээнд хэрэгжих төлөвлөгөөт бус гэрчлэх үнэлгээний нөхцөл, журмыг тайлбарласан болно.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү арга зүйн заавар нь MNAS-аас хэрэгжүүлэх менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага (МТББ)-ын итгэмжлэлийн үнэлгээний үйл ажиллагаанд үнэлгээний мэргэжилтнүүдийн баримтлах аргачлал, шаардлагыг тодорхойлно. Үүнд анхдагч итгэмжлэл, давтан итгэмжлэл, хүрээ өргөтгөх үнэлгээ, магадлах хяналт болон гомдлын дагуух үнэлгээ хамаарна.

Энэ баримт бичгийг ISO/IEC 17021-1 стандарт болон менежментийн тогтолцооны нэмэлт стандарт, олон улсын баримт бичгүүдэд үндэслэсэн бөгөөд үндсэндээ үнэлгээний мэргэжилтнүүдэд зориулсан болно. Гэсэн хэдий ч энэхүү баримт бичиг нь баталгаажуулалтын байгууллагад мөн хамааралтай тул итгэмжлэлийн шалгуур, үйл явцын талаарх нийтлэг ойлголтыг авах хүрээнд танилцах боломжтой.

3 НЭР ТОМЪЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1 Итгэмжлэл** - тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхитайг нь албан ёсоор харуулсан хөндлөнгийн этгээдийн баталгаа.
- 3.2 Баталгаажуулалтын байгууллага (ББ)** - Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу менежментийн тогтолцоог үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагаа явуулдаг, итгэмжлэлд хамрагдаж болох байгууллага.
- 3.3 Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага (МТББ)** - ISO/IEC 17021-1 стандартад нийцүүлэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг баталгаажуулалтын байгууллага
- 3.4 Магадлах хяналт** - Итгэмжлэл олгосны дараа итгэмжлэлийн шаардлагын хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор MNAS-аас гүйцэтгэдэг төлөвлөгөөт үнэлгээ.
- 3.5 Гэрчлэх үнэлгээ** - Итгэмжлэлийн үнэлгээний хүрээнд үнэлгээний мэргэжилтнүүд баталгаажуулалтын байгууллагын гүйцэтгэж буй аудитын үйл явц, аудитын багийн ажиллах чадавх болон хамааралтай үйл явцын хэрэгжилтийг ажиглаж, үнэлэх үйл ажиллагаа.
- 3.6 Хамрах хүрээ өргөтгөх** - Баталгаажуулалтын байгууллага итгэмжлэлийн хүчинтэй хугацаанд шинэ IAF код, техникийн кластер эсвэл нэмэлт баталгаажуулалтын үйл ажиллагааг хамруулах хүсэлт гаргасан тохиолдолд хийгддэг үнэлгээ.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 3/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

3.7 Гомдлын мөрөөр хийх үнэлгээ - Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдлын дагуу MNAS-аас хэрэгжүүлдэг газар дээрх болон/эсвэл оффисын үнэлгээ.

3.8 Анхдагч итгэмжлэл - Баталгаажуулалтын байгууллагыг анх удаа MNAS-аас итгэмжлэх зорилгоор хийгддэг иж бүрэн үнэлгээ.

3.9 Давтан итгэмжлэл - Итгэмжлэлийн хугацаа дуусахаас өмнө MNAS болон олон улсын шаардлагуудыг үргэлжлүүлэн хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор хэрэгжүүлдэг дахин итгэмжлэлийн үйл явц.

4 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

MNAS нь итгэмжлэлийн үнэлгээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцна. Энэхүү үйл ажиллагааг холбогдох стандарт болон хараат бус байдал, чадамж, нэгдмэл байдлыг хангах зарчимд нийцсэн байхаар хэрэгжүүлнэ.

(Итгэмжлэлийн) Үнэлгээний баг нь багийн ахлагч, үнэлгээчид болон техникийн шинжээчдээс бүрдэх ба мэргэжлийн өндөр түвшинд, ёс зүйн хэм хэмжээг чандлан баримтлан үнэлгээ гүйцэтгэх үүрэгтэй. Баг нь тухайн үнэлж буй хамрах хүрээнд холбогдох чадамжийг нотлон харуулахын зэрэгцээ нууцлал, хараат бус байдлыг хадгалах үүрэгтэй.

Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага (МТББ) нь итгэмжлэлийн үнэлгээний үйл явцын үеэр бүрэн хамтран ажиллах үүрэгтэй. Үүнд, итгэмжлэлийн хамрах хүрээнд хамаарах холбогдох бичиг баримт, ажилтан, үйлчлүүлэгчийн байршилд цаг тухайд нь хандах боломж олгох, мөн MNAS-ын бүх шаардлага, журам болон хугацааг чанд мөрдөх зэрэг багтана.

5 ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

MNAS-аар итгэмжлүүлэхийн тулд менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага (МТББ) нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ~ Хууль ёсны хуулийн этгээдээр бий болсон/бүртгэгдсэн байх;
- ~ ISO/IEC 17021-1 стандартад нийцсэн, баримтжуулсан менежментийн тогтолцоотой байх;
- ~ Баталгаажуулалтын үйл ажиллагаатай нь холбоотой техникийн чадамж, үйл ажиллагааны чадавхи, байгууллагын хараат бус байдлыг нотолж харуулах;
- ~ MNAS-аас тогтоосон загвар, шаардлагын дагуу бүрэн бүрдүүлсэн итгэмжлэлийн хүсэлт болон хавсралт баримт бичгүүдийг ирүүлэх;
- ~ MNAS-ын бүх холбогдох итгэмжлэлийн журам, үнэлгээ болон магадлах хяналтын шаардлагыг хүлээн зөвшөөрч мөрдөх, мөн итгэмжлэлийн үйл явцын хүрээнд тавигдах нөхцөл шаардлагуудыг биелүүлэх үүрэг хүлээх.

6 ИТГЭМЖЛЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ

6.1 Итгэмжлэлийн хүсэлт ба үнэлгээний төлөвлөлт

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 4/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

6.1.1 MNAS нь бүрэн гүйцэд бүрдүүлсэн итгэмжлэлийн хүсэлтийг хүлээн авсны дараа тухайн МТББ нь хүсэлт гаргагчийн шаардлагыг хангаж буй эсэхийг урьдчилан нягтална. Үүнд тухайн байгууллагын хуулийн этгээдийн нотолгоо болон бүртгэл, баталгаажуулалтын үйл ажиллагааны хамрах хүрээ, байгууллагын бүтэц зохион байгуулалт, чанарын гарын авлага, журам, хараат бус байдлын зохицуулалт, аудитын бүртгэл, ажилтнуудын чадамжийн мэдээлэл зэрэг менежментийн тогтолцооны баримт бичгийн бүрдэл, хангалттай байдал зэргийг баталгаажуулах хяналт багтах ба хэрэв ямар нэгэн дутуу зүйл илэрвэл MNAS нь үнэлгээний дараагийн шат руу шилжихээс өмнө тодруулга эсвэл нэмэлт баримт бичиг шаардана.

6.1.2 MNAS нь МТББ-ын итгэмжлэгдэхээр хүсэлт гаргаж буй хамрах хүрээ болон холбогдох IAF кодын дагуу үнэлгээний багийг томилох бөгөөд баг нь нийтдээ тухайн хамрах хүрээтэй холбоотой чиглэлд техникийн чадамжтай байна.

6.2 Үнэлгээний арга зүй

MNAS нь менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагууд (МТББ)-ын ISO/IEC 17021-1 стандарт болон холбогдох салбарын стандартад нийцэж буй байдал, чадамжийг үнэлэх зорилгоор төрөл бүрийн үнэлгээний аргыг хэрэгжүүлэх ба уг аргачлал нь баримт бичгийн хяналт, оффисын үнэлгээ, баталгаажуулалтын аудитын гэрчлэх үнэлгээ болон аудитын баримт бичгийн үнэлгээ зэргээс бүрдэнэ.

6.2.1 Баримт бичгийн дүн шинжилгээ

Газар дээрх үнэлгээ хийхээс өмнө MNAS нь МТББ-ын баримтжуулсан менежментийн тогтолцоонд дүн шинжилгээ хийнэ. Үүнд, шударга байдлын бодлого, журам, аудиторын чадамж, аудит төлөвлөлт ба хэрэгжилт, шийдвэр гаргах үйл явц, гомдол хүлээн авах, шийдвэрлэх, дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой бодлого, журам багтана. Мөн баримт бичгийн дүн шинжилгээгээр МТББ-ын үйл ажиллагаа нь ISO/IEC 17021-1 стандарт болон холбогдох IAF баримт бичгүүдийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг урьдчилсан байдлаар баталгаажуулна.

6.2.2 Оффис үнэлгээ

Энэ үнэлгээг МТББ-ын төв оффис эсвэл холбогдох үйл ажиллагааны байршилд гүйцэтгэнэ. Энэ нь баримтжуулсан журмын хэрэгжилтийг баталгаажуулах, баталгаажуулалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй тогтолцооны тохиромжтой байдлыг үнэлэхэд чиглэнэ. Үүнд аудиторын чадамж, мониторинг, аудитын хөтөлбөрийн төлөвлөлт, дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ болон баталгаажуулалтын шийдвэртэй холбоотой баримт бичгүүдийг үнэлэх үйл ажиллагаа зэрэг багтана.

6.2.3 Гэрчлэх үнэлгээ

Итгэмжлэлийн гэрчлэх үнэлгээ нь итгэмжлэлийн үнэлгээний чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь техникийн хүрээний гол үйл явцыг шалгах, аудиторуудын ур чадварыг харуулах зорилгоор сонгох үнэлгээ бөгөөд итгэмжлэлийн хамрах хүрээг төлөөлөх хэмжээнд байна. Ихэнхдээ гэрчлэх үнэлгээ нь 1 эсхүл 2 хүн, 2 өдөр байна. Энэ нь ISO/IEC 17021-1 болон бусад хөтөлбөрийн нэмэлт шаардлага стандартуудад тодорхойлсон өргөн хүрээний аудитын үйл явцыг харуулахад оршино.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 5/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

MNAS нь МТББ-аас хэрэгжүүлж буй сонгосон баталгаажуулалтын аудитад ажиглалт хийж, аудиторын чадамж болон аудитын үйл явцын үр нөлөөг баталгаажуулна. Үнэлгээний баг нь чухал IAF кодын хүрээнд анхдагч эсхүл давтан баталгаажуулалтын аудитыг гэрчлэхээр тэргүүн ээлжинд сонгох үүрэгтэй.

Гэрчлэх үнэлгээнд хамрагдах аудитыг сонгохдоо ОУИФ-ын заавал мөрдөх баримт бичгийн шаардлага, эрсдэлд суурилсан зарчим, чухал IAF код, техникийн бүлэглэл, болон аудитын үе шат (жишээлбэл: 1-р шат, 2-р шат, магадлах хяналтын аудит, дахин баталгаажуулалтын аудит)-ыг харгалзан үзнэ.

Гэрчлэх аудитын тоо, төрлийг шийдэхдээ MNAS дараахь хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- i) ББ-ын нийт гүйцэтгэл;
- ii) Баталгаажсан байгууллагын МТ-ны хүлээгдэж буй үр дүнд хүрэх чадварт нөлөөлдөг үйл явцын нарийн төвөгтэй байдал, хууль тогтоомж зэрэг хүчин зүйлс;
- iii) Баталгаажсан байгууллагын байгууллагын талаарх гомдол г.м сонирхогч талуудын ирүүлсэн мэдээлэл;
- iv) ББ-ын дотоод аудитын үр дүн;
- v) Схем эзэмшигчийн шаардлага г.м;
- vi) ББ-ын ажлын загвар дахь өөрчлөлт-тодорхой бус байдал, техникийн салбар дахь ажлын өсөлт;
- vii) ББ-ын итгэмжлэлийн хүрээн дэх үйлчлүүлэгчдийн тоо;
- viii) ББ-ын аудиторын үнэлгээ, хүлээн зөвшөөрөх үйл явцын найдвартай байдал; болон
- ix) өмнө хийгдсэн эсвэл бусад оффис эсвэл гэрчлэх үнэлгээний үр дүн гэх мэт багтана.

Харгалзах нэмэлт хүчин зүйлс:

- a) олгосон гэрчилгээний тоо;
- b) аудиторын тоо;
- c) төрөл бүрийн аудиторууд;
- d) аудиторууд нь дотоод эсвэл гадаад эх үүсвэрээс эсэх;
- e) төрөл бүрийн аудитууд, анхдагч баталгаажуулалт (1-р шат/2-р шат), магадлах шалгалт ба давтан баталгаажуулалт;
- f) нарийн төвөгтэй үйлчлүүлэгч, хамтарсан ба/эсвэл нэгдмэл аудит, олон салбарт хийх аудит;
- g) баталгаажуулалтын үйл явцад аудит гүйцэтгэх улс орнууд;
- h) сүүлд хийгдсэн гэрчлэх үнэлгээний үр дүн;
- i) гомдол, хэрэглэгчийн судалгаа;
- j) сонирхогч талууд ба захиргааны байгууллагын шаардлага;
- k) өмнө нь үнэлсэн техникийн бүлгүүд;
- l) ББ-ын итгэмжлэлийн бусад төрлүүдээс хуримтлуулсан туршлага;
- m) ББ өөрийн үйл ажиллагааг өмнө нь удирдаж байсан чадвартай эсэх;
- n) ББ өөрийн чухал үйл ажиллагааг хянах хяналтын түвшин;
- o) тодорхой схемийн шаардлага;
- p) үйлчлүүлэгчтэй хийсэн үндэсний хэлэлцээр.

Баталгаажуулалтын байгууллага, хэрэв боломжтой бол MNAS үнэлгээний баг болон баталгаажуулалтын байгууллагын үнэлгээний баг нь гэрчлэх үнэлгээний нээлтийн хурлын өмнө богино хэмжээний уулзалтыг хийх боломжийг хангасан байна. Энэ уулзалтын зорилго

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 6/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

нь гэрчлэх үнэлгээний мөн чанар, хамрах хүрээ, хүлээлтийг тодорхойлж, аудитын явцад оролцогчдын үүрэг, мэргэжлийн ёс зүйн талаар нийтлэг ойлголттой байдлыг хангахад оршино.

Гэрчлэх үнэлгээ нь ихэвчлэн нээлтийн хурлаас хаалтын хурал хүртэлх баталгаажуулалтын аудитын бүх үйл явцыг хамарна. Гэвч үнэлгээний зорилгод хүрэх боломжтой бол хэсэгчилсэн байдлаар гэрчлэх үнэлгээ хийхийг зөвшөөрнө. MNAS-ын үнэлгээний баг аудитын явцад хөндлөнгөөс оролцох, МТББ болон түүний үйлчлүүлэгчид санал, зөвлөмж өгөх, үзэл бодлоо илэрхийлэх эсвэл үйлчлүүлэгчээс шууд асуулт асуух, ярилцлага хийхийг хориглоно. Харилцаа зөвхөн завсарлага эсвэл үнэлгээний багийн дотоод хурлын үеэр явагдана.

Гэрчлэх үнэлгээний дараа MNAS нь баталгаажуулалтын байгууллагын аудитын багт ажиглалтын үр дүнгийн талаар танилцуулна. Үүнийг баталгаажуулалтын байгууллагын удирдлагад мөн танилцуулж болох ба баталгаажуулалтын байгууллагын үйлчлүүлэгч оролцохыг хориглоно.

Баталгаажуулалтын байгууллагын аудитын тайлан болон аудитын үеэр хянан үзсэн холбогдох баримт бичигт MNAS-ын үнэлгээний мэргэжилтний хүсэлтийн дагуу танилцах боломжийг МТББ олгоно. Ингэхдээ эдгээр бүх мэдээллийг MNAS-ын бодлогын дагуу нууцын зэрэглэлтэйгээр авч үзнэ.

Гэрчлэх үнэлгээний нарийвчилсан журам болон хөтөлбөр тус бүрийн шаардлагыг үнэлгээний мэргэжилтнүүд энэхүү арга зүйн зааврын холбогдох хавсралтууд болон IAF-ын заавал мөрдөх баримт бичгүүдээс лавлан ашиглаж болно. Үүнд:

- Хавсралт В - Чанарын менежментийн тогтолцоо (QMS), Хавсралт С - Байгаль орчны менежментийн тогтолцоо (EMS), Хавсралт Е - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо (OHSMS) нь IAF MD 17 баримт бичгийн шаардлагад нийцсэн байна.
- Хавсралт D-д Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны (FSMS) гэрчлэх үнэлгээний үед энэхүү заавар болон IAF MD 16 баримт бичгийг авч ашиглана.

Эдгээр баримт бичиг нь аудитын сонголт, эрсдэлийн ангилал, гэрчлэх давтамж, нөхөн арга хэмжээний зохицуулалтын шалгуурыг тодорхойлж, бүх менежментийн тогтолцооны хамрах хүрээнд үнэлгээний үр дүнгийн нэг ижил зарчим, техникийн үндэслэлтэй байдал, нийцлийг хангах үндэс болно.

Гэрчлэх үнэлгээний явцад ноцтой үл тохирол илэрсэн тохиолдолд MNAS нь ижил төстэй баталгаажуулалтын аудитад дахин гэрчлэх үнэлгээ зохион байгуулахыг МТББ-аас шаардаж болно. Энэхүү арга хэмжээ нь залруулах үйл ажиллагааны үр нөлөөг баталгаажуулах зорилготой. Давтагдсан үл тохирол, эсвэл шийдвэрлэгдээгүй дутагдал илэрсэн нөхцөлд MNAS нь итгэмжлэлийн үйл явцын журмын дагуу тухайн МТББ-ын итгэмжлэлийн хамрах хүрээг багасгах, түдгэлзүүлэх хүртэлх арга хэмжээ авна.

6.2.3.1 Төлөвлөгөөт гэрчлэх үнэлгээ

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 7/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

МТББ нь итгэмжлэлийн үнэлгээний өмнө буюу хамгийн багадаа 15 хоногийн өмнө төлөвлөж буй аудитын хуваариа MNAS-д ирүүлнэ. Аудитын хуваарьт харилцагчийн мэдээлэл, аудитын огноо, үе шат, холбогдох IAF кодын мэдээлэл тусгагдсан байна.

Мөн гэрчлэх үйл ажиллагаанаас өмнө, хамгийн багадаа нэг долоо хоногийн өмнө MNAS-ын үнэлгээний багт дараах баримт бичгийг хүргүүлэх шаардлагатай. Үүнд:

- Менежментийн тогтолцооны гарын авлага болон журам (хэрэв байгаа бол);
- Өмнөх аудитын тайлангууд (хэрэв байгаа бол);
- Баталгаажуулалтын схемийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- Аудитын багийн бүрэлдэхүүний мэдээлэл;
- Аудитын хугацааны тооцоолол;
- MNAS-аас шаардсан бусад холбогдох баримт бичиг.

6.2.3.2 Төлөвлөгөөт бус гэрчлэх үнэлгээ

MNAS нь магадлан хяналт хийх явцад эсвэл эрсдэл, гомдол, мөн тодорхой чиглэлд үйл ажиллагаа дутагдсан гэж үзсэн тохиолдолд төлөвлөгөөгүй гэрчлэх үнэлгээг эхлүүлж болно. Энэ үнэлгээ нь MNAS-д шаардлагад үргэлжлүүлэн нийцэж байгааг шалгах, холбогдох асуудлуудыг шийдвэрлэх боломжийг олгоно.

Төлөвлөөт бус гэрчлэх үнэлгээ хийх нөхцлүүдэд дараахь зүйлс багтах байх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Баталгаажуулсан үйлчлүүлэгчидтэй холбогдсон ноцтой гомдлууд;
- Гурван жилээс дээш хугацаанд тодорхой чиглэлд баталгаажуулалтын үйл ажиллагаа байхгүй байх;
- МТББ-ны байгууллага, үйл явцад орсон томоохон өөрчлөлтүүд;
- MNAS-аас эрсдэлтэй гэж авч үзсэн санамсаргүй сонголт.

6.2.4 Аудитын баримт бичгийн хяналт

MNAS нь МТББ-ын гүйцэтгэсэн баталгаажуулалтын аудитын баримт бичгүүдээс түүвэрлэн тус хяналтыг явуулна. Энэ үйл ажиллагаа нь баталгаажуулалтын байгууллагын аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал болон баталгаажуулалтын шийдвэр гаргалт нь хэрхэн шаардлагад нийцэж байгааг нотлох, тогтолцоо нь бүрдэж хэвшсэн байдлыг үнэлэх зорилготой. Аудитын баримт бичгийн хяналт нь аудитын тайлан, шалгах хуудсууд, үл тохирол, санал, бусад холбогдох ажиглалт бүхий дүгнэлт, баталгаажуулалтын шийдвэрийн баримт бичгүүдийг хамарна. Ингэхдээ аудиторын ур чадварын нотолгоо болон аудитын бүхий л үйл явц дахь шударга байдлын механизмд онцгой анхаарал хандуулвал зохино.

6.2.5 Эрсдэлд суурилсан түүвэрлэх зарчим

Үнэлгээний баг нь MD 17 болон MD 23 баримт бичигт нийцсэн эрсдэлд суурилсан түүвэрлэх зарчмыг баримтална. Аудит болон баримт бичгийг үнэлэх арга хэрэгслүүдийг сонгохдоо МТББ-ын үйлчлүүлэгчдийн хүрээ, итгэмжлэлийн хамрах хүрээ, гэрээт болон гадаад аудитор ашигласан байдал, хамрагдаж буй салбарын нарийн төвөгтэй байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Алсын зайн аудит болон олон салбартай байгууллагын баталгаажуулалтыг холбогдох IAF-ын шаардлагын дагуу үнэлнэ.

6.3 Үнэлгээний үр дүнг тайлагнах

6.3.1 Үнэлгээний баг нь үнэлгээний явцад ажиглагдсан бүх холбогдох ажиглалтыг, үүнд үл тохирол, сайжруулах арга хэмжээний хүрээнд өгч буй зөвлөмж, давуу тал (шаардлагатай тохиолдолд) баримтжуулах үүрэгтэй.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 8/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

6.3.2 Үнэлгээний багийн ахлагч нь үнэлгээний үйл ажиллагаа, итгэмжлэлийн шаардлага, шалгуурт нийцэж буй байдал, үнэлгээний явцад илэрсэн бүх ажиглалтыг нэгтгэн дүгнэсэн дэлгэрэнгүй үнэлгээний тайланг бэлтгэнэ.

6.3.3 Баталгаажуулалтын байгууллага нь MNAS-аас тогтоосон хугацааны дотор үнэлгээний багийн ахлагчид дараах зүйлсийг багтаасан хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлнэ. Үүнд:

- **(a) Үл тохирлын хувьд:**
 - Учир шалгааны шинжилгээ хийсэн болон залруулах арга хэмжээ авсан баримт; болон
 - Залруулах арга хэмжээний үр дүнтэй байдлын нотолгоо, хэрэв бүрэн хэрэгжилт хараахан хийгдээгүй бол — хэрэгжилтийн эцсийн хугацааг тусгасан төлөвлөгөө
- **(b) Ажил сайжруулах зөвлөмжийн хувьд:**
 - Хариу өгөхийг зөвлөмжилж буй бөгөөд заавал байх шаардлагагүй.

***Тайлбар:** Баталгаажуулалтын байгууллагын хэрэгжүүлсэн ажлын тайланг үнэлгээний тайлан дахь тухайн илэрсэн үл тохирол бүрийн доор бичиж, шаардлагатай бол авсан залруулах арга хэмжээний нотлох баримтыг хавсаргана.*

6.3.4 Багийн ахлагч нь ирүүлсэн залруулах арга хэмжээний хангалттай байдал, үр нөлөөг хянан, үнэлж, итгэмжлэлийн шийдвэр гаргахтай холбоотой санал, дүгнэлтийг боловсруулан MNAS-д ирүүлнэ.

6.4 Итгэмжлэлийг хадгалах

6.4.1 Итгэмжлэлийн статусыг хадгалахын тулд МТББ нь ISO/IEC 17021-1 стандарт, холбогдох салбарын нэмэлт стандартууд, мөн MNAS-ын журам болон итгэмжлэлийн нөхцөл шаардлагуудыг байнга, тогтмол мөрдөх үүрэгтэй.

МТББ-ын үндсэн үүрэгт дараах зүйлс хамаарна. Үүнд:

- Итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж буйг үнэлэх магадлах хяналт болон давтан үнэлгээнд амжилттай хамрагдах;
- Үнэлгээний үр дүнд өгөгдсөн ажлын үр дүн, шаардлагыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Баталгаажуулалтын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй байгууллагын бүтцийн өөрчлөлт, хуулийн статус, голлох ажилтан зэрэг чухал мэдээллийг MNAS-д тухай бүр гэрээнд дурдсанаар мэдээлэх;
- MNAS-тай хамтран ажиллах, шаардлагатай бичиг баримт, ажилтан, талбайд нэвтрэх боломж олгох;
- Итгэмжлэлтэй холбоотой төлбөр, хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
- MNAS-аас гаргасан бүх заавар, шаардлагыг биелүүлэх.

6.4.2 Дээрх үүрэг, шаардлагыг хангаагүй тохиолдолд итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хамрах хүрээг багасгах, эсвэл хүчингүй болгох шийдвэр гаргаж болно.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 9/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

6.4.3 MNAS нь МТББ итгэмжлэлийн шалгуурт үргэлжлүүлэн нийцэж буйг баталгаажуулах зорилгоор жил бүр магадлах хяналт, дөрвөн (анхдагч итгэмжлэлийн хувьд хоёр) жил тутам давтан үнэлгээ хийдэг. Эдгээр үнэлгээ нь ББ-ын хамрах хүрээ, эрсдэлийн түвшин, үйлчлүүлэгчийн цар хүрээг харгалзан оффисын үнэлгээ, бичиг баримтын шалгалт, гэрчлэх үнэлгээг багтаана. Гэрчлэх үнэлгээг итгэмжлэлийн мөчлөгийн туршид хуваарилан гүйцэтгэх бөгөөд өндөр эрсдэлтэй болон чухал IAF кодтой салбарт онцгой анхаарал хандуулна. Мөн итгэмжлэлийн мөчлөг бүрийн хугацаанд чухал бүлэг тус бүрээс дор хаяж нэг гэрчлэх аудит заавал хийгдсэн байх шаардлагатай.

6.4.4 Итгэмжлэлийн мөчлөгийн туршид MNAS-ийн үнэлгээний баг нь аль болох баталгаажуулалтын байгууллагын нөөцөд байгаа бүх тэргүүлэх аудитор, аудитор, техникийн шинжээчдийн ажлыг гэрчлэх үнэлгээнд хамруулсан байх шаардлагатай. Иймд баталгаажуулалтын байгууллага нь гэрчлэх үнэлгээ бүрт өөр өөр багийн гишүүдийг томилно.

6.4.5 Хэрэв тодорхой хүрээнд гэрчлэх үнэлгээ хийх боломжгүй бол MNAS нь аудиторын мэргэшлийг бүртгэлийн анкетыг үзэх эсвэл ярилцлагаар үнэлж болно. Хэрэв ямар нэг итгэмжлэгдсэн хүрээнд үйл ажиллагаа байхгүй бол тухайн хүрээг багасгах, түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

6.4.6 Итгэмжлэлийн хүрээ өргөтгөх үед MNAS нь заавал нэг удаа шийдвэрлэх кодын эсхүл тухайн хамрах хүрээнд гэрчлэх үнэлгээ хийх шаардлагатай. Хэрэв баталгаажуулалтын үйл ажиллагаа байхгүй бол MNAS нь хамрах хүрээ өргөтгөх үнэлгээг хойшлуулна.

6.4.7 МТББ нь олгосон гэрчилгээний мэдээллийг IAF MD 28 баримт бичигт заасны дагуу сар бүр дор хаяж нэг удаа IAF CertSearch мэдээллийн санд байршуулна. Хэрэв мэдээлэлд алдаа, зөрүү эсвэл дутуу зүйл илэрсэн тохиолдолд тухайн мэдээллийг илрүүлсэн даруйд, уртдаа хоёр долоо хоногийн дотор засварлаж, гүйцэт, зөв мэдээллийг байршуулах үүрэгтэй.

6.5 Гэрчлэх үнэлгээний нэмэлт зохицуулалт

6.5.1 Баталгаажуулалтын байгууллага (ББ) нь өөрийн үйлчлүүлэгчдээ MNAS-ын үнэлгээний мэргэжилтэн аудитын явцад оролцох тухай урьдчилан мэдэгдэж, гэрчлэх үнэлгээг тайлбарлан, үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авах үүрэгтэй. Зөвхөн гэрчлэх үнэлгээний улмаас ББ нь аудитын баг, аудитын төлөвлөгөө, аудитын хугацаанд өөрчлөлт оруулах шаардлагагүй. Хэрэв ямар нэгэн өөрчлөлт хийх тохиолдолд ББ нь уг өөрчлөлтийн үндэслэл, тайлбарыг MNAS-д албан ёсоор мэдэгдэнэ.

6.5.2 ББ-ийн үйлчлүүлэгч нь аудит эхлэхээс өмнө ББ-ийн аудитын баг болон MNAS-ын үнэлгээний мэргэжилтнүүдэд байгууллагын аюулгүй ажиллагаа болон нэвтрэх журамтай холбоотой шаардлагыг бүрэн танилцуулах үүрэгтэй. MNAS-ын үнэлгээний мэргэжилтэн нь тухайн байгууллагаас тогтоосон аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд мөрдөнө. Гэсэн хэдий ч, үнэлгээний мэргэжилтэн нь гэмтэл, эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд өөрийн оролцоог зогсоох, тухайн газрыг орхих зэрэг арга хэмжээг өөрсдийн зүгээс авах эрхтэй.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 10/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

6.5.3 Аудитын явцад MNAS-ын үнэлгээний мэргэжилтний зүгээс эрүүл мэнд, аюулгүй байдал эсхүл байгаль орчинд ноцтой хохирол учруулах шууд аюултай нөхцөл байдлыг илрүүлсэн тохиолдолд энэхүү асуудлыг ББ-ийн аудитын багийн ахлагчид хувийн уулзалт зохион байгуулж яаралтай мэдэгдэнэ. Энэхүү асуудлыг ББ нь өөрийн дотоод журам болон холбогдох хууль, эрх зүйн шаардлагын дагуу зохих арга хэмжээг авч шийдвэрлэх үүрэгтэй.

6.5.4 MNAS-ын үнэлгээний мэргэжилтэн нь аудитын бүх үе шатыг хамруулан гэрчлэх үнэлгээ хийгээгүй тохиолдолд үнэлгээний тайланд гэрчлэх үед ажигласан аудитын үйл ажиллагаа, үе шат, аудитын төлөвлөгөөний холбогдох хэсэг, үнэлгээ хийсэн менежментийн тогтолцооны шаардлагыг тусгайлан тэмдэглэнэ.

6.5.5 Хэрэв ББ нь үндсэн бүртгэлээс гадаад байршилд үйлчлүүлэгчдийг баталгаажуулсан бол тухайн үйлчлүүлэгчийн мэдээллийг MNAS-д мэдэгдэнэ. MNAS нь тухайн үйлчлүүлэгчийн аудитыг гэрчлэх үнэлгээний төлөвлөгөөнд оруулах эсэхийг шийднэ.

7 ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- **MNAS P402** Нууцыг хадгалах журам
- **MNAS P602** Итгэмжлэлийн үйл ажиллагаанд оролцох ажилтныг үнэлэх, гүйцэтгэлд мониторинг хийж журам
- **MNAS P701** Итгэмжлэлийн үйл явцын журам
- **MNAS P702** Итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох буюу хүрээг багасгах, өргөтгөх журам

---XXX---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо:24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 11/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

ХАВСРАЛТ А: Менежментийн тогтолцооны бүтэц болон тавигдах шаардлагын тодорхойлолт

Менежментийн тогтолцооны төрөл	Үндсэн хүрээ (Стандарт) ОУИФ-ын 3-р түвшин	Нэмэлт итгэмжлэлийн баримт бичиг ОУИФ-ын 4-р түвшин, дэд хүрээ	ОУИФ-ын ЗМББ, нэмэлт шаардлага ОУИФ-ын 4-р түвшин, дэд хүрээ	Баталгаажуулалтын стандарт ОУИФ-ын 5-р түвшин, дэд хүрээ
ЧМТ (Чанар)	ISO/IEC 17021-1:2015	ISO/IEC 17021-3:2017	IAF MD 1, 2, 4, 5, 11, 12, 17, 23	ISO 9001:2015
БОМТ (Байгаль орчин)	ISO/IEC 17021-1:2015	ISO/IEC 17021-2:2016	IAF MD 1, 2, 4, 5, 11, 12, 17, 23	ISO 14001:2015
ХАБМТ (Хүнсний аюулгүй байдал)	ISO/IEC 17021-1:2015	ISO 22003-1:2022	IAF MD 1, 2, 4, 11, 12, 16, 23	ISO 22000:2018
ХЭМАБМТ (Хөдөлмөр)	ISO/IEC 17021-1:2015	ISO/IEC 17021-10:2018	IAF MD 1, 2, 4, 5, 11, 12, 17, 22, 23	ISO 45001:2018
МАБМТ (Мэдээллийн аюулгүй байдал)	ISO/IEC 17021-1:2015	ISO/IEC 27006-1:2024	IAF MD 1, 2, 4, 11, 12, 13, 23	ISO/IEC 27001:2022
АЭМТ (Авлигын эсрэг)	ISO/IEC 17021-1:2015	ISO/IEC TS 17021-9:2016	IAF MD 1, 2, 4, 11, 12, 23	ISO 37001:2016
ЭХМТ (Эрчим хүч)	ISO/IEC 17021-1:2015	ISO 50003:2021	IAF MD 1, 2, 4, 11, 12, 23	ISO 50001:2018
МТҮМТ (Мэдээллийн технологийн үйлчилгээ)	ISO/IEC 17021-1:2015	ISO/IEC 20000-6:2017	IAF MD 1, 2, 4, 11, 12, 23	ISO/IEC 20000-1:2018
ХММТ (Хувийн мэдээллийн МТ)	ISO/IEC 17021-1:2015	ISO/IEC 27006:2015 ISO/IEC 27001:2013	IAF MD 1, 2, 4, 11, 12, 23	ISO/IEC 27701:2019

Тайлбар:

- Дээрх хүснэгтэд эш татсан IAF-ын шаардлагууд нь шилжилтийн үе шаттай байгааг анхаарна уу. Хамгийн сүүлийн хувилбаруудыг IAF-ын цахим хуудасны Хэвлэл цэснээс үзнэ үү.
- Дээр дурдсан холбогдох дэд хамрах хүрээний бүх стандартууд нь энэ баримт бичиг нийтлэгдсэн үеийн хүчинтэй хувилбар гэдгийг анхаарна уу. Хамгийн сүүлийн хувилбарыг Олон улсын стандартчиллын байгууллага (ISO) эсвэл тухайн стандарт боловсруулдаг байгууллагын цахим хуудаснаас лавлана уу.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 12/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

ХАВСРАЛТ В: ЧМТ (ISO 9001)-ны гэрчлэх үнэлгээ

1. ЗОРИЛГО:

Чанарын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрийн хүрээнд гэрчлэх үнэлгээг төлөвлөх, итгэмжлэлийн хамрах хүрээний салбаруудыг ангилахтай холбоотой зааврыг тодорхойлоход оршино. Энд өгөгдсөн хамрах хүрээний ангилал нь мөн аудиторын чадамжийг тогтоох техникийн салбаруудыг тодорхойлох үндэс болно.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү хавсралт нь Чанарын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрт хамаарна.

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Гэрчлэх үнэлгээний хамрах хүрээний ангилал

MNAS нь гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө боловсруулахдаа техникийн чиглэлүүдийг IAF MD 17 баримт бичигт тусгагдсан IAF-ийн хамрах хүрээний дагуу ангилсан болно.

3.1.1 ЧМТ-ны итгэмжлэлийн хөтөлбөрийн эхний хоёр итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд MNAS нь техникийн бүлэг тус бүр дээр дор хаяж нэг удаа гэрчлэх үнэлгээ хийж ажиллана. Энэхүү итгэмжлэлийн хөтөлбөр нь дараалсан хоёр итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд баталгаажуулалтын байгууллага нь хангалттай туршлага, гүйцэтгэлээ харуулж, дараах хүчин зүйлсийг үнэлсний үндсэн дээр сайжруулсан итгэмжлэлийн хөтөлбөрт хамрагдах хүртэл үргэлжилнэ. Үүнд:

- a) Баталгаажуулалтын байгууллагын нийт гүйцэтгэл
 - i) MNAS-аас тогтоосон хугацааны дагуу хяналт, дахин итгэмжлэл болон гэрчлэх үнэлгээг зохион байгуулсан байдал.
 - ii) MNAS-ын үнэлгээний төлөвлөгөө, түүн дотор гэрчлэх үнэлгээнд бүрэн нийцсэн байдал
 - iii) Сүүлийн итгэмжлэлийн мөчлөгт томоохон/ноцтой үл тохирол илрээгүй байх
 - iv) Сүүлийн хоёр итгэмжлэлийн мөчлөгийн үеийн үл тохирол, анхаарах хэсгийг MNAS-аас тогтоосон хугацаанд хугацаанд шийдвэрлэсэн байдал
- b) Сонирхогч талууд болон баталгаажсан байгууллагуудаас шийдвэрлэгдээгүй сөрөг санал, гомдол байхгүй байх
- c) Хөтөлбөрийн эзэмшигчээс тавьсан хориг, арга хэмжээ байхгүй байх
- d) Холбогдох зохицуулагч байгууллагаас сөрөг санал, хар жагсаалтад оруулаагүй байх
- e) MNAS-д төлөх төлбөрийг хугацаанд нь төлсөн, өр төлбөргүй байх
- f) Бусад холбогдох мэдээлэл

Тайлбар: Хэрэв баталгаажуулалтын байгууллага санаатайгаар ташаа, худал мэдээлэл өгвөл тухайн байгууллагын хэрэгжүүлж буй сайжруулсан итгэмжлэлийн хөтөлбөрийг цуцална.

Сайжруулсан хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед MNAS нь техникийн кластер бүрт заавал нэг удаа гэрчлэх үнэлгээ хийж, түүнтэй хавсарсан бусад үнэлгээний арга хэмжээг (жишээ нь:

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 13/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

оффисын үнэлгээний үеийн үйлчлүүлэгчийн болон ажилтны файл шалгалт, алсаас тайлангийн хяналт гэх мэт) хэрэгжүүлнэ. Ингэснээр хоёр дараалсан итгэмжлэлийн мөчлөгийн турш техникийн кластер бүрийг үнэлсэн байх шаардлагыг хангана. Хэрэв ББ-ын аудиторын чадамж тогтоох үйл явц, аудит хийх арга барил, үр дүн болон аудиторын бүрэлдэхүүнд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан тохиолдолд эхний итгэмжлэлийн мөчлөгт тогтоосон гэрчлэх үнэлгээний давтамжийг дахин мөрдөнө.

Шаардсан тохиолдолд баталгаажуулалтын байгууллага нь MNAS-д баталгаажсан болон төлөвлөсөн аудитуудын (огноо, байршил, аудитын багийн бүрэлдэхүүн, аудитын төрөл, баталгаажуулалтын хамрах хүрээ, IAF код гэх мэт) бүрэн бөгөөд шинэчилсэн хуваарийг яаралтай хүргүүлэх үүрэгтэй. Энэ нь MNAS-д итгэмжлэлийн хамрах хүрээг хянах үнэлгээний хөтөлбөрийг төлөвлөх, шинэчлэх боломжийг бүрдүүлэх зорилготой.

3.1.2 Дараах гэрчлэх дүрмийг хүсэлт гаргасан хамрах хүрээг зохистой хамарна гэдгээ батлахын тулд өөр бусад үнэлгээний ажиллагаагаар нэмэгдүүлэх ЧМТ-ны схем бүрийн итгэмжлэлийг олгох, өргөтгөхөд мөрдөнө. Үүнд:

- i) Хэрэв техникийн бүлэг зөвхөн нэг шийдвэрлэх кодтой байвал MNAS нь энэ бүлэг дэх IAF-ийн бүх кодыг итгэмжлэхийн тулд тухайн шийдвэрлэх кодонд гэрчлэх үнэлгээ гүйцэтгэнэ. Жишээ нь: ЧМТ-ны хувьд, Хүнсний бүлгийн IAF 03 кодын дагуу 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, MNAS бусад IAF кодууд (01 ба 30)-д итгэмжлэл олгож болно.
- ii) Хэрэв техникийн бүлэг 1-ээс илүү шийдвэрлэх кодтой байвал MNAS наад зах нь “эсвэл”-тэй тогтоосон шийдвэрлэх кодуудын (“Шийдвэрлэх код” баганад) аль нэгт гэрчлэх үнэлгээ хийнэ. Тухайлбал ЧМТ-ны хувьд, Уул уурхай бүлгийн IAF 2 эсвэл 15 кодын аль нэгт 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, тухайн техникийн бүлгийн бусад IAF кодууд (2, 15, 16)-д итгэмжлэл олгож болно.
- iii) Хэрэв техникийн бүлэг 1-ээс илүү шийдвэрлэх кодтой байвал MNAS наад зах нь “ба”-тай тогтоосон бүх шийдвэрлэх кодуудын (“Шийдвэрлэх код” баганад) аль нэгт гэрчлэх үнэлгээ хийнэ.
- iv) Хэрэв шийдвэрлэх IAF кодонд гэрчлэх үнэлгээ хийх боломжгүй бол MNAS эдгээр хоёр сонголтын нэгийг ББ-тай тохиролцоно. Үүнд:
 - a) MNAS зөвхөн гэрчлэх үнэлгээ хийсэн техникийн бүлгийнхээ шийдвэрлэх бус IAF кодонд итгэмжлэл олгож болно (жишээ нь: ЧМТ-ны Хүнсний бүлэгт IAF 30 кодын дагуу нэг гэрчлэх үнэлгээ хийсэн бол, MNAS-аас IAF 30, 01 код хоёуланд итгэмжлэл олгож болно). Эсхүл
 - b) MNAS шийдвэрлэх кодонд дараах нөхцөлтэйгөөр оффис үнэлгээ явуулж, бүлгийн бүх кодуудад итгэмжлэл олгож болно. Эдгээр нөхцөл нь:
 - ББ бүлгийн бүх кодонд баримт бичгийн хувьд ажиллах ур чадвартайгаа харуулсан; болон
 - Баталгаажуулалтын гэрчилгээ олгохоос өмнө итгэмжлэлийн хүрээнд орсон шийдвэрлэх кодуудад гэрчлэх үнэлгээ явуулах бол.

Гэвч энэ тохиолдолд хэрэв гэрчлэх үнэлгээний үр дүн муу гарвал ИБ итгэмжлэлийн хүрээг багасгах тухай авч үзнэ.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 14/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

Тайлбар: Итгэмжлэлийн гэрчилгээтэй байгаа итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага нь хэрэв тухайн шийдвэрлэх (critical) кодоор итгэмжлэлтэй боловч түүнд хамаарах шийдвэрлэх бус (non-critical) кодоор итгэмжлэлгүй бол §3.1.6-ийн дагуу хамрах хүрээг нь өргөтгөн уг шийдвэрлэх бус кодыг багтаах боломжтой.

3.1.3 Хэрэв баталгаажуулалтын байгууллага зөвхөн нэг эсвэл хэд хэдэн шийдвэрлэх бус IAF кодоор итгэмжлэл авахыг хүсвэл, шийдвэрлэх бус IAF код агуулсан бүлэг тус бүр дээр дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ хийх шаардлагатай.

3.1.4 ЧМТ-ны схемийн анхдагч итгэмжлэлд, MNAS нь ББ-ын үйлчлүүлчдээс наад зах нь нэгийнх нь 1 ба 2 шатны аудитад хоёуланд гэрчлэх үнэлгээ явуулна. Тухайн аудитын 2 шатыг гэрчлэхээс өмнө хүсэлт гаргагч ББ аудитын 1 шатнаас гарсан дүгнэлт эсвэл бэлэн болсон тайланг ИБ-ын үнэлгээний багт өгнө. Хэрэв ББ-т шинэ үйлчлүүлэгч байхгүй бол түлхүүр үйл явцыг хамарсан 1 дахин баталгаажуулалт эсвэл 2 магадлан хяналтыг гэрчлэх боломжтой.

3.1.5 IAF кодонд бүхэлд нь итгэмжлэл олгох нь тухайн ББ тухайн техникийн бүх хэсэгт баталгаажуулалтыг зохион байгуулах чадвартайгаа харуулж чадах эсэхээс хамаарна.

Тайлбар: зарим ИБ нь IAF кодыг дотор нь NACE код эсвэл IAF дэд-кодод хувааж нарийвчлан хэрэглэдэг учир “бүхэлд нь” гэдэг үгийг ашигласан болно.

3.1.6 Мөн MNAS итгэмжлэл олгохоос өмнө бүх шийдвэрлэх бус кодуудын чадамжийг үнэлэх шаардлагатай. Иймээс итгэмжлэлийг зөвхөн дараах зүйлсд олгоно. Үүнд:

- i) ББ аль хэдийн баталгаажуулах шийдвэр гаргасан IAF кодонд тухайлбал, ЧМТ-ны IAF 03 кодын дагуу 1 гэрчлэх үнэлгээтэй үед MNAS нь Баталгаажуулалтын байгууллага IAF 01 кодын дагуу шийдвэр гаргаагүй тохиолдолд зөвхөн IAF 30, 03 кодын хүрээнд зөвхөн итгэмжлэл олгоно. Эсхүл
- ii) ББ өөр бусад байдлаар чадамжаа нотлон харуулсан IAF кодонд (жишээ нь: бүх нарийвчилсан баталгаажуулалтын үйл ажиллагаандаа чадамж бүхий ажилтнуудтай гэдгээ харуулах - ISO/IEC 17021-н Хавсралт А-г үзнэ үү).

3.1.7 Нэгтгэсэн эсвэл хосолсон менежментийн тогтолцооны аудит явуулах тохиолдолд гэрчлэх үнэлгээний хамрах хүрээг ББ-тай зөвшилцсөн байна. Хэрэв гэрчлэх үнэлгээг ижил кодоор өөр зорилгоор (жишээ нь: ISO 13485, ISO 3834, EN 9100) ойрын хугацаанд гүйцэтгэсэн бол MNAS дахин гэрчлэх ажиллагаа явуулах хэрэгтэй эсэхийг авч үзнэ.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 15/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

Хамрах хүрээний бүлэг

Техникийн бүлэг		ОУИФ код	IAF ID 1-д заасан эдийн засгийн сектор/үйл ажиллагааны тайлбар	Шийдвэрлэх код
БҮЛЭГ 1	Хүнс	1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй	3
		3	Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тамхи	
		30	Зочид буудал, рестарон	
БҮЛЭГ 2	Механик	17	Ердийн метал, бэлэн металл бүтээгдэхүүн	22 эсвэл 20
		18	Машин, тоног төхөөрөмж	
		19	Цахилгаан ба оптик тоног төхөөрөмж	
		20	Хөлөг онгоцны үйлдвэрлэл	
		22	Бусад тээвэрлэх тоног төхөөрөмж	
БҮЛЭГ 3	Цаас	7	“Цаасан бүтээгдэхүүн”-ээр хязгаарлагдсан	9
		8	Нийтлэлийн компани	
		9	Хэвлэлийн компани	
БҮЛЭГ 4	Эрдэс	2	Уурхай, олборлолт	2 эсвэл 15
		15	Метал бус эрдсийн бүтээгдэхүүн	
		16	Бетон, цемент, шохой, гипс	
БҮЛЭГ 5	Барилга байгууламж	28	Барилга байгууламж	28
		34	Инженерчлэлийн үйлчилгээ	
БҮЛЭГ 6	Бараа үйлдвэрлэл	4	Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн	5 эсвэл 14
		5	Савхи ба савхин бүтээгдэхүүн	
		6	Мод, модон бүтээгдэхүүн	
		14	Резин, хуванцар бүтээгдэхүүн	
		23	Аль ч ангилалд багтахгүй үйлдвэрлэл	
БҮЛЭГ 7	Химийн бодис	7	“Ислэг ба цаас үйлдвэрлэл”-ээр хязгаарлагдсан	12
		10	Кокс ба сайжруулсан газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл	
		12	Химийн бодис, химийн бүтээгдэхүүн, утас	
БҮЛЭГ 8	Хангамж	25	Цахилгаан хангамж	26
		26	Хийн хангамж	
		27	Усан хангамж	
БҮЛЭГ 9	Тээвэрлэлт, Хаягдлын менежмент	24	Дахин боловсруулах	24
		31	Тээвэрлэлт, агуулах ба харилцаа холбоо	
		39	Нийгмийн бусал үйлчилгээ	
БҮЛЭГ 10	Үйлчилгээ	29	Бөөний ба жижиглэн худалдаа; моторт тээврийн хэрэгсэл, мотоцикл, хувийн болон гэр ахуйн барааны засвар	37 эсвэл 33
		32	Санхүүгийн зуулчлал, үл хөдлөх хөрөнгө, түрээс	
		33	Мэдээллийн технологи	
		35	Бусад үйлчилгээ	
		37	Боловсрол	
		36	Төрийн захиргаа	
БҮЛЭГ 11	Цөмийн	11	Цөмийн түлш	11
БҮЛЭГ 12	Эм бэлдмэл	13	Эм бэлдмэл	13
БҮЛЭГ 13	Нисэх	21	Нисэх	21
БҮЛЭГ 14	Эрүүл мэнд	38	Эрүүл мэнд ба нийгмийн хамгаалал	38

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо:24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 16/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

ХАВСРАЛТ С: БОМТ (ISO 14001)-ны гэрчлэх үнэлгээ

1. ЗОРИЛГО:

Байгаль орчны менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрийн хүрээнд гэрчлэх үнэлгээг төлөвлөх, итгэмжлэлийн хамрах хүрээний салбаруудыг ангилахтай холбоотой зааврыг тодорхойлоход оршино. Энд өгөгдсөн хамрах хүрээний ангилал нь мөн аудиторын чадамжийг тогтоох техникийн салбаруудыг тодорхойлох үндэс болно.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү хавсралт нь Байгаль орчны менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрт хамаарна.

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Гэрчлэх үнэлгээний хамрах хүрээний ангилал

MNAS нь гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө боловсруулахдаа техникийн чиглэлүүдийг IAF MD 17 баримт бичигт тусгагдсан IAF-ийн хамрах хүрээний дагуу ангилсан болно.

3.1.1 БОМТ-ны итгэмжлэлийн хөтөлбөрийн эхний хоёр итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд MNAS нь техникийн бүлэг тус бүр дээр дор хаяж нэг удаа гэрчлэх үнэлгээ хийж ажиллана. Энэхүү итгэмжлэлийн хөтөлбөр нь дараалсан хоёр итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд баталгаажуулалтын байгууллага нь хангалттай туршлага, гүйцэтгэлээ харуулж, дараах хүчин зүйлсийг үнэлсний үндсэн дээр сайжруулсан итгэмжлэлийн хөтөлбөрт хамрагдах хүртэл үргэлжилнэ. Үүнд:

- a) Баталгаажуулалтын байгууллагын нийт гүйцэтгэл
 - i) MNAS-аас тогтоосон хугацааны дагуу хяналт, дахин итгэмжлэл болон гэрчлэх үнэлгээг зохион байгуулсан байдал.
 - ii) MNAS-ын үнэлгээний төлөвлөгөө, түүн дотор гэрчлэх үнэлгээнд бүрэн нийцсэн байдал
 - iii) Сүүлийн итгэмжлэлийн мөчлөгт томоохон/ноцтой үл тохирол илрээгүй байх
 - iv) Сүүлийн хоёр итгэмжлэлийн мөчлөгийн үеийн үл тохирол, анхаарах хэсгийг MNAS-аас тогтоосон хугацаанд хугацаанд шийдвэрлэсэн байдал
- b) Сонирхогч талууд болон баталгаажсан байгууллагуудаас шийдвэрлэгдээгүй сөрөг санал, гомдол байхгүй байх
- c) Хөтөлбөрийн эзэмшигчээс тавьсан хориг, арга хэмжээ байхгүй байх
- d) Холбогдох зохицуулагч байгууллагаас сөрөг санал, хар жагсаалтад оруулаагүй байх
- e) MNAS-д төлөх төлбөрийг хугацаанд нь төлсөн, өр төлбөргүй байх
- f) Бусад холбогдох мэдээлэл

Тайлбар: Хэрэв баталгаажуулалтын байгууллага санаатайгаар ташаа, худал мэдээлэл өгвөл тухайн байгууллагын хэрэгжүүлж буй сайжруулсан итгэмжлэлийн хөтөлбөрийг цуцална.

Сайжруулсан хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед MNAS нь техникийн кластер бүрт заавал нэг удаа гэрчлэх үнэлгээ хийж, түүнтэй хавсарсан бусад үнэлгээний арга хэмжээг (жишээ нь:

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 17/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

оффисын үнэлгээний үеийн үйлчлүүлэгчийн болон ажилтны файл шалгалт, алсаас тайлангийн хяналт гэх мэт) хэрэгжүүлнэ. Ингэснээр хоёр дараалсан итгэмжлэлийн мөчлөгийн турш техникийн кластер бүрийг үнэлсэн байх шаардлагыг хангана. Хэрэв ББ-ын аудиторын чадамж тогтоох үйл явц, аудит хийх арга барил, үр дүн болон аудиторын бүрэлдэхүүнд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан тохиолдолд эхний итгэмжлэлийн мөчлөгт тогтоосон гэрчлэх үнэлгээний давтамжийг дахин мөрдөнө.

Шаардсан тохиолдолд баталгаажуулалтын байгууллага нь MNAS-д баталгаажсан болон төлөвлөсөн аудитуудын (огноо, байршил, аудитын багийн бүрэлдэхүүн, аудитын төрөл, баталгаажуулалтын хамрах хүрээ, IAF код гэх мэт) бүрэн бөгөөд шинэчилсэн хуваарийг яаралтай хүргүүлэх үүрэгтэй. Энэ нь MNAS-д итгэмжлэлийн хамрах хүрээг хянах үнэлгээний хөтөлбөрийг төлөвлөх, шинэчлэх боломжийг бүрдүүлэх зорилготой.

3.1.2 Дараах гэрчлэх дүрмийг хүсэлт гаргасан хамрах хүрээг зохистой хамарна гэдгээ батлахын тулд өөр бусад үнэлгээний ажиллагаагаар нэмэгдүүлэх ЧМТ-ны схем бүрийн итгэмжлэлийг олгох, өргөтгөхөд мөрдөнө. Үүнд:

- i) Хэрэв техникийн бүлэг зөвхөн нэг шийдвэрлэх кодтой байвал MNAS нь энэ бүлэг дэх IAF-ийн бүх кодыг итгэмжлэхийн тулд тухайн шийдвэрлэх кодонд гэрчлэх үнэлгээ гүйцэтгэнэ. Жишээ нь: БОМТ-ны хувьд, Цаасны бүлэгт IAF 09 кодын дагуу 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, MNAS тухайн бүлгийн бусад IAF кодууд (7 ба 8)-д итгэмжлэл олгож болно.
- ii) Хэрэв техникийн бүлэг 1-ээс илүү шийдвэрлэх кодтой байвал MNAS наад зах нь “ба”-тай тогтоосон бүх шийдвэрлэх кодуудын (“Шийдвэрлэх код” баганад) аль нэгт гэрчлэх үнэлгээ хийнэ. Тухайлбал, БОМТ-ны хувьд, Бараа үйлдвэрлэлийн бүлгийн IAF 04 эсвэл 05 кодын аль нэгт 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, тухайн техникийн бүлгийн бүх шийдвэрлэх биш кодууд (06 ба 23)-д итгэмжлэл олгож болно, гэвч бусад шийдвэрлэх кодууд (04 эсвэл 05)-д гэрчлэх үнэлгээ хийж байж итгэмжлэл олгоно.
- iii) Хэрэв техникийн бүлэг 1-ээс илүү шийдвэрлэх кодтой байвал MNAS наад зах нь “эсвэл”-тэй тогтоосон шийдвэрлэх кодуудын (“Шийдвэрлэх код” баганад) аль нэгт гэрчлэх үнэлгээ хийнэ. Тухайлбал, БОМТ-ны хувьд, Хангамж бүлгийн IAF 25 эсвэл 26 кодын аль нэгт 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, тухайн техникийн бүлгийн IAF 25, 26, 27 кодуудад итгэмжлэл олгож болно.
- iv) Хэрэв шийдвэрлэх IAF кодонд гэрчлэх үнэлгээ хийх боломжгүй бол MNAS эдгээр хоёр сонголтын нэгийг ББ-тай тохиролцоно. Үүнд:
 - a) MNAS зөвхөн гэрчлэх үнэлгээ хийсэн техникийн бүлгийнхээ шийдвэрлэх бус IAF кодонд итгэмжлэл олгож болно (жишээ нь: БОМТ-ны Цаасны бүлгийн IAF 7 кодонд нэг гэрчлэх үнэлгээ хийсэн бол, MNAS-аас IAF 07, 08 код хоёуланд итгэмжлэл олгож болно). Эсхүл
 - b) MNAS шийдвэрлэх кодонд дараах нөхцөлтэйгөөр оффис үнэлгээ явуулж, бүлгийн бүх кодуудад итгэмжлэл олгож болно. Эдгээр нөхцөл нь:
 - ББ бүлгийн бүх кодонд баримт бичгийн хувьд ажиллах ур чадвартайгаа харуулсан; болон

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 18/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

- Баталгаажуулалтын гэрчилгээ олгохоос өмнө итгэмжлэлийн хүрээнд орсон шийдвэрлэх кодуудад гэрчлэх үнэлгээ явуулах бол.

Гэвч энэ тохиолдолд хэрэв гэрчлэх үнэлгээний үр дүн муу гарвал ИБ итгэмжлэлийн хүрээг багасгах тухай авч үзнэ.

Тайлбар: Итгэмжлэлийн гэрчилгээтэй байгаа итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага нь хэрэв тухайн кодоор итгэмжлэлтэй боловч түүнд хамаарах шийдвэрлэх бус кодоор итгэмжлэлгүй бол §3.1.6-ийн дагуу хамрах хүрээг нь өргөтгөн уг шийдвэрлэх бус кодыг багтаах боломжтой.

3.1.3 Хэрэв баталгаажуулалтын байгууллага зөвхөн нэг эсвэл хэд хэдэн шийдвэрлэх бус IAF кодоор итгэмжлэл авахыг хүсвэл, шийдвэрлэх бус IAF код агуулсан бүлэг тус бүр дээр дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ хийх шаардлагатай.

3.1.4 БОМТ-ны схемийн анхдагч итгэмжлэлд, MNAS нь ББ-ын үйлчлүүлчдээс наад зах нь нэгийнх нь 1 ба 2 шатны аудитад хоёуланд гэрчлэх үнэлгээ явуулна. Тухайн аудитын 2 шатыг гэрчлэхээс өмнө хүсэлт гаргагч ББ аудитын 1 шатнаас гарсан дүгнэлт эсвэл бэлэн болсон тайланг ИБ-ын үнэлгээний багт өгнө. Хэрэв ББ-т шинэ үйлчлүүлэгч байхгүй бол түлхүүр үйл явцыг хамарсан 1 дахин баталгаажуулалт эсвэл 2 магадлан хяналтыг гэрчлэх боломжтой.

3.1.5 IAF кодонд бүхэлд нь итгэмжлэл олгох нь тухайн ББ тухайн техникийн бүх хэсэгт баталгаажуулалтыг зохион байгуулах чадвартайгаа харуулж чадах эсэхээс хамаарна.

Тайлбар: зарим ИБ нь IAF кодыг дотор нь NACE код эсвэл IAF дэд-кодод хувааж нарийвчлан хэрэглэдэг учир “бүхэлд нь” гэдэг үгийг ашигласан болно.

3.1.6 Мөн MNAS итгэмжлэл олгохоос өмнө бүх шийдвэрлэх бус кодуудын чадамжийг үнэлэх шаардлагатай. Иймээс итгэмжлэлийг зөвхөн дараах зүйлд олгоно. Үүнд:

- ББ аль хэдийн баталгаажуулах шийдвэр гаргасан IAF кодонд тухайлбал, БОМТ-ны IAF 09 кодын дагуу 1 гэрчлэх үнэлгээтэй үед MNAS нь Баталгаажуулалтын байгууллага IAF 08 кодын дагуу шийдвэр гаргаагүй тохиолдолд зөвхөн IAF 07, 09 кодын хүрээнд итгэмжлэл олгоно. Эсхүл
- ББ өөр бусад байдлаар чадамжаа нотлон харуулсан IAF кодонд (жишээ нь: бүх нарийвчилсан баталгаажуулалтын үйл ажиллагаандаа чадамж бүхий ажилтнуудтай гэдгээ харуулах - ISO/IEC 17021-н Хавсралт А-г үзнэ үү).

3.1.7 Нэгтгэсэн эсвэл хосолсон менежментийн тогтолцооны аудит явуулах тохиолдолд гэрчлэх үнэлгээний хамрах хүрээг ББ-тай зөвшилцсөн байна. Хэрэв гэрчлэх үнэлгээг ижил кодоор өөр зорилгоор (жишээ нь: ISO 13485, ISO 3834, EN 9100) ойрын хугацаанд гүйцэтгэсэн бол MNAS дахин гэрчлэх ажиллагаа явуулах хэрэгтэй эсэхийг авч үзнэ.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 19/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

Хамрах хүрээний бүлэг

Техникийн бүлэг		ОУИФ код	IAF ID 1-д заасан эдийн засгийн сектор/үйл ажиллагааны тайлбар	Шийдвэр-лэх код
БҮЛЭГ 1	ХАА, ойн АА, загасны АА	1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй	1
БҮЛЭГ 2	Хүнс	3	Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тамхи	3
		30	Зочид буудал, рестарон	
БҮЛЭГ 3	Механик	17	“Метал бүтээгдэхүүн”-ээр хязгаарлагдсан	20 эсвэл 21
		18	Машин, тоног төхөөрөмж	
		19	Цахилгаан ба оптик тоног төхөөрөмж	
		20	Хөлөг онгоц үйлдвэрлэл	
		21	Нисэх	
		22	Бусад тээвэрлэх төхөөрөмж	
БҮЛЭГ 4	Цаас	7	“Цаасан бүтээгдэхүүн”-ээр хязгаарлагдсан	9
		8	Нийтлэлийн компани	
		9	Хэвлэлийн компани	
БҮЛЭГ 5	Барилга байгууламж	28	Барилга байгууламж	28
		34	Инженерчлэлийн үйлчилгээ	
БҮЛЭГ 6	Бараа үйлдвэрлэл	4	Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн	4 ба 5
		5	Савхи, савхин бүтээгдэхүүн	
		6	Мод, модон бүтээгдэхүүн	
		23	Аль ч ангилалд багтахгүй үйлдвэрлэл	
БҮЛЭГ 7	Химийн бодис	7	“Ислэг ба цаас үйлдвэрлэл”-ээр хязгаарлагдсан	7 ба 10 ба 12 ба 13
		10	Кокс ба сайжруулсан газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл	
		12	Химийн бодис, химийн бүтээгдэхүүн, утас	
		13	Эм бэлдмэл	
		14	Резин, хуванцар бүтээгдэхүүн	
		15	Метал бус эрдсийн бүтээгдэхүүн	
		16	Бетон, цемент, шохой, гипс г.м	
БҮЛЭГ 8	Уурхай ба олборлолт	2	Уурхай ба олборлолт	2
БҮЛЭГ 9	Хангамж	25	Цахилгаан хангамж	25 эсвэл 26
		26	Хийн хангамж	
		27	Усан хангамж	
БҮЛЭГ 10	Тээвэрлэлт, Хаягдлын менежмент	31	Тээвэрлэлт, агуулах, харилцаа холбоо	24 ба 39 (NACE 37, 38.1, 38.2, 39-өөр хязгаарлагдсан)
		24	Дахин боловсруулах	
		39	Бусад нийгмийн үйлчилгээ	
БҮЛЭГ 11	Үйлчилгээ	29	Бөөний ба жижиглэн худалдаа; Моторт тээврийн хэрэгслийн, мотоцикл ба хувийн болон гэр ахуйн барааны засвар	29 эсвэл 35 эсвэл 36
		32	Санхүүгийн зуулчлал, үл хөдлөх хөрөнгө, түрээс	
		33	Мэдээллийн технологи	
		35	Бусад үйлчилгээ	
		36	Төрийн захиргаа	
		37	Боловсрол	
БҮЛЭГ 12	Цөмийн	11	Цөмийн түлш	11
БҮЛЭГ 13	Эрүүл мэнд	38	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	38

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 20/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

ХАВСРАЛТ D: FSMS (ISO 22000)-ны гэрчлэх үнэлгээ

1. ЗОРИЛГО:

Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрийн хүрээнд гэрчлэх үнэлгээг төлөвлөх, итгэмжлэлийн хамрах хүрээний салбаруудыг ангилахтай холбоотой зааврыг тодорхойлоход оршино. Энд өгөгдсөн хамрах хүрээний ангилал нь мөн аудиторын чадамжийг тогтоох техникийн салбаруудыг тодорхойлох үндэс болно.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү хавсралт нь Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрт хамаарна.

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Гэрчлэх үнэлгээний хамрах хүрээний ангилал

3.1.1 MNAS нь ISO 22003-1:2022 стандартын Хавсралт А, Хүснэгт А.1-д тодорхойлсон А ангиллаас К хүртэлх 11 хүнсний сүлжээний ангиллыг IAF MD 16 баримт бичгийн шаардлагад нийцүүлэн дараах 8 бүлэг (багц)-т хуваасан. Үүнд,

БҮЛЭГ	ISO 22003-1:2022 стандартад заасан кластерууд
Анхдагч үйлдвэрлэл	A + B
Хүн, амьтанд зориулсан хоол хүнс боловсруулалт	C + D
Хоол/Хоолны үйлчилгээ	E
Жижиглэн худалдаа, тээвэрлэлт, хадгалалт	F + G
Туслах үйлчилгээ	H
Сав баглаа боодлын материал	I
Туслах тоног төхөөрөмж	J
(Био) Химийн бодис	K

3.1.2 Итгэмжлэлийн хамрах хүрээг ISO 22003-1:2022 стандартын Хавсралт А, Хүснэгт А.1-д заасан кластеруудад хамаарах хүнсний сүлжээний ангиллуудаар илэрхийлнэ. Хэрэв хамрах хүрээг тухайн ангиллын тодорхой дэд ангилалаар хязгаарласан бол энэхүү хязгаарлалтыг итгэмжлэлийн хамрах хүрээнд тодорхой, нэг утгатайгаар тусгана.

3.1.3 Итгэмжлэлийн байгууллага нь кластерт дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ хийлгүйгээр тухайн хүнсний сүлжээний ангилалд итгэмжлэл олгохгүй.

Тайлбар: Энэ шалгуур нь итгэмжлэлийн хамрах хүрээг өргөтгөхөд мөн хамаарна. Бүлэг доторх өргөтгөлийн хувьд гэрчлэх үнэлгээ заавал байх албагүй. Шинэ бүлгээр хүрээ өргөтгөхөд гэрчлэх үнэлгээ заавал хийх шаардлагатай.

3.1.4 Энэ хавсралтын 3.1.3-т заасан шаардлага нь хамгийн бага шалгуур юм (4.1.8-д заасан тохиолдлоос бусад). MNAS оффисын үнэлгээний үр дүн, ББ-д (MNAS болон бусад ИБ-аас)

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 21/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

олгосон ХАБМТ-ны итгэмжлэл, үйл явцын эрсдэл зэрэгт үндэслэн тохиолдол бүрийг үнэлж, тодорхой нөхцөл байдалд нэмэлт гэрчлэх үнэлгээ шаардлагатай эсэхийг шийднэ.

3.1.5 MNAS нь жил бүр 2-р бүлэгт (хэрэв баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн хүрээнд орсон бол) нэгээс доошгүй аудитыг, итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд бусад багц тус бүрд дор хаяж нэг аудитын гэрчлэх үнэлгээ хийнэ.

3.1.6 Гэрчлэх үнэлгээнд хамрагдах байгууллага болон баталгаажуулах байгууллагын үйл ажиллагааны онцлог нь үндэслэлтэй тохиолдолд нэг гэрчлэх үнэлгээнд өөр ангиллыг хамруулж болно.

3.1.7 MNAS нь итгэмжлэлийн мөчлөгийн туршид боломжит бүх тохиолдолд хүнсний аюулгүй байдлын аюулын эрсдэл өндөртэй дэд ангилалд гэрчлэх үнэлгээ хийнэ.

3.1.8 MNAS нь гэрчлэх үнэлгээг хийх шаардлагатай эсэхийг шийдвэрлэхдээ хүнсний аюулгүй байдлын бусад стандарт эсвэл схем (менежментийн тогтолцоо эсвэл бүтээгдэхүүний баталгаажуулалтын схем)-ийн ижил бүлэгт хамаарах ангиллын баталгаажуулалтын байгууллагад олгосон итгэмжлэлийг харгалзан үзэж болно. Энэ тохиолдолд MNAS нь 3.1.4-оос 3.1.6-д заасан гэрчлэх үнэлгээний ихэнх бус харин тодорхой хэсгийг орлуулахын тулд ийм схемийн аль нэгээр гүйцэтгэсэн гэрчлэх үнэлгээний үр дүнг ашиглаж болно. Энэ нь үйлчлүүлэгчдийн баталгаажуулалтын үйл ажиллагаа болон баталгаажуулалтын байгууллагын аудитуудын хуваарилалтад үндэслэсэн байна. Эдгээр тохиолдлуудыг MNAS үндэслэлтэй гэдгийг нотлон, бүрэн баримтжуулна.

3.2 Итгэмжлэл олгох нөхцөл, шаардлага

3.2.1 ISO 22003-1-ийн Хавсралт А-ийн А.1 хүснэгтэд заасан хүнсний сүлжээний нэг буюу хэд хэдэн ангилал/дэд ангиллын хүрээнд итгэмжлэл олгох нь тухайн ББ эдгээр хүнсний сүлжээний ангилал/дэд ангиллуудад Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (ХАБМТ)-ны баталгаажуулалтын үйлчилгээ (жишээлбэл ISO 22000)-г хүргэх чадвартайгаа харуулж, нотолсон гэж үзнэ. Гэвч энэ нь ББ нь тухайн хүнсний сүлжээний ангиллын хүрээнд орсон бүх дэд ангилалд шаардлагатай ур чадвар бүхий аудитуудтай гэсэн үг биш юм. Иймээс, тодорхой хүнсний сүлжээний ангилал/дэд ангилалд итгэмжлэл олгохоос өмнө дор дурдсан нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай.

3.2.2 MNAS нь дараах нөхцөлүүдийг хангаж байгаа тохиолдолд баталгаажуулалтын байгууллагад тодорхой хүнсний сүлжээний ангиллын хүрээнд итгэмжлэл олгоно. Үүнд:

- Гэрээг шалгах, хүнсний сүлжээний ангилал, дэд ангиллыг зөв сонгох ур чадвартай ажилтантай байх (ISO 22003-1 стандартын Хавсралт С-ийг үзнэ үү);
- Тодорхойлсон дэд ангилал тус бүрт ажиллах ажилтнуудын ур чадварыг тодорхойлох техникийн шалгуурыг тогтоосон байх;
- Хүнсний сүлжээний ангиллын дор хаяж нэг дэд ангилалд хамаарах чадамжтай ажилтантай байх;

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 22/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

- d) Зөвхөн баталгаажуулалтын байгууллагад чадамжтай ажилтан нь байгаа дэд ангилалд итгэмжлэгдсэн баталгаажуулалтыг санал болгоно гэсэн баталгаа өгөх үйл явцыг бий болгох;
- e) Чадамжтай, ур чадвартай ажилтантай байгаа дэд ангиллын жагсаалтыг тогтмол шинэчилдэг байх. Ингэхдээ тус жагсаалтыг MNAS-ын хүсэлтээр өгөх боломжтой байх.
- f) Итгэмжлэл авахыг хүсч буй хүнсний сүлжээний ангилалд дор хаяж нэг идэвхтэй эсвэл боломжит баталгаажуулалтын өргөдөлтэй гэдгээ харуулах.

3.2.3 Дээрх нөхцөлүүдийг хангаж байгаа эсэхийг анхдагч итгэмжлэлийн газар дээрх үнэлгээ болон итгэмжлэлийн хүрээ өргөтгөх үед хийх газар дээрх/алсын зайн үнэлгээ хийх замаар MNAS шалгана. Ингэхдээ шаардлагатай тохиолдолд MNAS-ын үнэлгээний баг ББ-ын аудиторууд болон техникийн мэргэжилтнүүдтэй нүүр тулсан (хэрэв боломжтой бол) эсвэл алсын зайнаас ярилцлага хийнэ.

3.2.4 Зарим тохиолдолд итгэмжлэл хүсч буй байгууллага дээр дурдсан бүх нөхцөлийг хангах боломжгүй, эсвэл тухайн ангиллын зарим дэд ангилалд л үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан, эсвэл энэхүү хавсралтын 3.1-т заасан гэрчлэх үнэлгээний шаардлагыг хангаж чадахгүй бол MNAS дэд ангилал(ууд)-аар хязгаарлагдсан хүрээнд итгэмжлэл олгоно.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 23/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

ХАВСРАЛТ Е: ХЭМАБМТ (ISO 45001)-ны гэрчлэх үнэлгээ

1. ЗОРИЛГО:

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрийн хүрээнд гэрчлэх үнэлгээг төлөвлөх, итгэмжлэлийн хамрах хүрээний салбаруудыг ангилахтай холбоотой зааврыг тодорхойлоход оршино. Энд өгөгдсөн хамрах хүрээний ангилал нь мөн аудиторын чадамжийг тогтоох техникийн салбаруудыг тодорхойлох үндэс болно.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү хавсралт нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрт хамаарна.

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Гэрчлэх үнэлгээний хамрах хүрээний ангилал

MNAS нь гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө боловсруулахдаа техникийн чиглэлүүдийг IAF MD 22 баримт бичгийн Хавсралт В-д тусгагдсан IAF-ийн хамрах хүрээний дагуу ангилсан болно.

3.1.1 ХЭМАБМТ-ны итгэмжлэлийн хөтөлбөрийн эхний хоёр итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд MNAS нь техникийн бүлэг тус бүр дээр дор хаяж нэг удаа гэрчлэх үнэлгээ хийж ажиллана. Энэхүү итгэмжлэлийн хөтөлбөр нь дараалсан хоёр итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд баталгаажуулалтын байгууллага нь хангалттай туршлага, гүйцэтгэлээ харуулж, дараах хүчин зүйлсийг үнэлсний үндсэн дээр сайжруулсан итгэмжлэлийн хөтөлбөрт хамрагдах хүртэл үргэлжилнэ. Үүнд:

- a) Баталгаажуулалтын байгууллагын нийт гүйцэтгэл
 - i) MNAS-аас тогтоосон хугацааны дагуу хяналт, дахин итгэмжлэл болон гэрчлэх үнэлгээг зохион байгуулсан байдал.
 - ii) MNAS-ын үнэлгээний төлөвлөгөө, түүн дотор гэрчлэх үнэлгээнд бүрэн нийцсэн байдал
 - iii) Сүүлийн итгэмжлэлийн мөчлөгт томоохон/ноцтой үл тохирол илрээгүй байх
 - iv) Сүүлийн хоёр итгэмжлэлийн мөчлөгийн үеийн үл тохирол, анхаарах хэсгийг MNAS-аас тогтоосон хугацаанд хугацаанд шийдвэрлэсэн байдал
- b) Сонирхогч талууд болон баталгаажсан байгууллагуудаас шийдвэрлэгдээгүй сөрөг санал, гомдол байхгүй байх
- c) Хөтөлбөрийн эзэмшигчээс тавьсан хориг, арга хэмжээ байхгүй байх
- d) Холбогдох зохицуулагч байгууллагаас сөрөг санал, хар жагсаалтад оруулаагүй байх
- e) MNAS-д төлөх төлбөрийг хугацаанд нь төлсөн, өр төлбөргүй байх
- f) Бусад холбогдох мэдээлэл

Тайлбар: Хэрэв баталгаажуулалтын байгууллага санаатайгаар ташаа, худал мэдээлэл өгвөл тухайн байгууллагын хэрэгжүүлж буй сайжруулсан итгэмжлэлийн хөтөлбөрийг цуцална.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 24/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

Сайжруулсан хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед MNAS нь техникийн кластер бүрт заавал нэг удаа гэрчлэх үнэлгээ хийж, түүнтэй хавсарсан бусад үнэлгээний арга хэмжээг (жишээ нь: оффисын үнэлгээний үеийн үйлчлүүлэгчийн болон ажилтны файл шалгалт, алсаас тайлангийн хяналт гэх мэт) хэрэгжүүлнэ. Ингэснээр хоёр дараалсан итгэмжлэлийн мөчлөгийн турш техникийн кластер бүрийг үнэлсэн байх шаардлагыг хангана. Хэрэв ББ-ын аудиторын чадамж тогтоох үйл явц, аудит хийх арга барил, үр дүн болон аудиторын бүрэлдэхүүнд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан тохиолдолд эхний итгэмжлэлийн мөчлөгт тогтоосон гэрчлэх үнэлгээний давтамжийг дахин мөрдөнө.

Шаардсан тохиолдолд баталгаажуулалтын байгууллага нь MNAS-д баталгаажсан болон төлөвлөсөн аудитуудын (огноо, байршил, аудитын багийн бүрэлдэхүүн, аудитын төрөл, баталгаажуулалтын хамрах хүрээ, IAF код гэх мэт) бүрэн бөгөөд шинэчилсэн хуваарийг яаралтай хүргүүлэх үүрэгтэй. Энэ нь MNAS-д итгэмжлэлийн хамрах хүрээг хянах үнэлгээний хөтөлбөрийг төлөвлөх, шинэчлэх боломжийг бүрдүүлэх зорилготой.

3.1.2 Дараах гэрчлэх дүрмийг хүсэлт гаргасан хамрах хүрээг зохистой хамарна гэдгээ батлахын тулд өөр бусад үнэлгээний ажиллагаагаар нэмэгдүүлэх ХЭМАБМТ-ны схем бүрийн итгэмжлэлийг олгох, өргөтгөхөд мөрдөнө. Үүнд:

- i) Хэрэв техникийн бүлэг зөвхөн нэг шийдвэрлэх кодтой байвал MNAS нь энэ бүлэг дэх IAF-ийн бүх кодыг итгэмжлэхийн тулд тухайн шийдвэрлэх кодонд гэрчлэх үнэлгээ гүйцэтгэнэ. Жишээ нь: ХЭМАБМТ-ны хувьд, Цаасны бүлэгт IAF 09 кодын дагуу 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, MNAS тухайн бүлгийн бусад IAF кодууд (7 ба 8)-д итгэмжлэл олгож болно.
- ii) Хэрэв техникийн бүлэг 1-ээс илүү шийдвэрлэх кодтой байвал MNAS наад зах нь “ба”-тай тогтоосон бүх шийдвэрлэх кодуудын (“Шийдвэрлэх код” баганад) аль нэгт гэрчлэх үнэлгээ хийнэ. Тухайлбал, ХЭМАБМТ-ны хувьд Механик бүлгийн IAF 20 эсвэл 21 кодын аль нэгт 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, тухайн техникийн бүлгийн бүх шийдвэрлэх биш кодууд (17, 18, 19, 22)-д итгэмжлэл олгож болно, гэвч бусад шийдвэрлэх кодууд (20 эсвэл 21)-д гэрчлэх үнэлгээ хийж байж итгэмжлэл олгоно.
- iii) Хэрэв техникийн бүлэг 1-ээс илүү шийдвэрлэх кодтой байвал MNAS наад зах нь “эсвэл”-тэй тогтоосон шийдвэрлэх кодуудын (“Шийдвэрлэх код” баганад) аль нэгт гэрчлэх үнэлгээ хийнэ. Тухайлбал, ХЭМАБМТ-ны хувьд, Хангамж бүлгийн IAF 25 эсвэл 26 кодын аль нэгт 1 гэрчлэх үнэлгээ хийж байж, тухайн техникийн бүлгийн 25, 26, 27 кодуудад итгэмжлэл олгож болно.
- iv) If a technical cluster has more than 1 critical codes identified with “and” and “or” at the end, by witnessing the critical code identified with “or” at the end, MNAS can grant all the codes in that cluster.; e.g. for OHSMS, in cluster Chemical, with 1 witnessing activity in IAF code 17, MNAS can grant accreditation in the other IAF codes (7,10,12,13,14,15 and 16) of that technical cluster;
- v) Хэрэв шийдвэрлэх IAF кодонд гэрчлэх үнэлгээ хийх боломжгүй бол MNAS эдгээр хоёр сонголтын нэгийг ББ-тай тохиролцоно. Үүнд:
 - а) MNAS зөвхөн гэрчлэх үнэлгээ хийсэн техникийн бүлгийнхээ шийдвэрлэх бус IAF кодонд итгэмжлэл олгож болно (жишээ нь: ХЭМАБМТ-ны Цаасны бүлэгт

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 25/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

IAF 7 кодонд нэг гэрчлэх үнэлгээ хийсэн бол, MNAS-аас IAF 07, 08 код хоёуланд итгэмжлэл олгож болно). Эсхүл

b) MNAS шийдвэрлэх кодонд дараах нөхцөлтэйгөөр оффис үнэлгээ явуулж, бүлгийн бүх кодуудад итгэмжлэл олгож болно. Эдгээр нөхцөл нь:

- ББ бүлгийн бүх кодонд баримт бичгийн хувьд ажиллах ур чадвартайгаа харуулсан; болон
- Баталгаажуулалтын гэрчилгээ олгохоос өмнө итгэмжлэлийн хүрээнд орсон шийдвэрлэх кодуудад гэрчлэх үнэлгээ явуулах бол.

Гэвч энэ тохиолдолд хэрэв гэрчлэх үнэлгээний үр дүн муу гарвал MNAS итгэмжлэлийн хүрээг багасгах тухай авч үзнэ.

Тайлбар: Итгэмжлэлийн гэрчилгээтэй байгаа итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага нь хэрэв тухайн шийдвэрлэх кодоор итгэмжлэлтэй боловч түүнд хамаарах шийдвэрлэх бус кодоор итгэмжлэлгүй бол §3.1.6-ийн дагуу хамрах хүрээг нь өргөтгөн уг шийдвэрлэх бус кодыг багтаах боломжтой.

3.1.3 Хэрэв баталгаажуулалтын байгууллага зөвхөн нэг эсвэл хэд хэдэн шийдвэрлэх бус IAF кодоор итгэмжлэл авахыг хүсвэл, шийдвэрлэх бус IAF код агуулсан бүлэг тус бүр дээр дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ хийх шаардлагатай.

3.1.4 ХЭМАБМТ-ны схемийн анхдагч итгэмжлэлд, MNAS нь ББ-ын үйлчлүүлчдээс наад зах нь нэгийнх нь 1 ба 2 шатны аудитад хоёуланд гэрчлэх үнэлгээ явуулна. Тухайн аудитын 2 шатыг гэрчлэхээс өмнө хүсэлт гаргагч ББ аудитын 1 шатнаас гарсан дүгнэлт эсвэл бэлэн болсон тайланг MNAS-ын үнэлгээний багт өгнө. Хэрэв ББ-т шинэ үйлчлүүлэгч байхгүй бол түлхүүр үйл явцыг хамарсан 1 дахин баталгаажуулалт эсвэл 2 магадлан хяналтыг гэрчлэх боломжтой.

3.1.5 IAF кодонд бүхэлд нь итгэмжлэл олгох нь тухайн ББ тухайн техникийн бүх хэсэгт баталгаажуулалтыг зохион байгуулах чадвартайгаа харуулж чадах эсэхээс хамаарна.

Тайлбар: зарим ИБ нь IAF кодыг дотор нь NACE код эсвэл IAF дэд-кодод хувааж нарийвчлан хэрэглэдэг учир “бүхэлд нь” гэдэг үгийг ашигласан болно.

3.1.6 Мөн MNAS итгэмжлэл олгохоос өмнө бүх шийдвэрлэх бус кодуудын чадамжийг үнэлэх шаардлагатай. Иймээс итгэмжлэлийг зөвхөн дараах зүйлсд олгоно. Үүнд:

- i) ББ аль хэдийн баталгаажуулах шийдвэр гаргасан IAF кодонд тухайлбал, БОМТ-ны IAF 09 кодын дагуу 1 гэрчлэх үнэлгээтэй үед MNAS нь Баталгаажуулалтын байгууллага IAF 08 кодын дагуу шийдвэр гаргаагүй тохиолдолд зөвхөн IAF 07, 09 кодын хүрээнд итгэмжлэл олгоно. Эсхүл
- ii) ББ өөр бусад байдлаар чадамжаа нотлон харуулсан IAF кодонд (жишээ нь: бүх нарийвчилсан баталгаажуулалтын үйл ажиллагаандаа чадамж бүхий ажилтнуудтай гэдгээ харуулах - ISO/IEC 17021-н Хавсралт А-г үзнэ үү).

3.1.7 Нэгтгэсэн эсвэл хосолсон менежментийн тогтолцооны аудит явуулах тохиолдолд гэрчлэх үнэлгээний хамрах хүрээг ББ-тай зөвшилцсөн байна. Хэрэв гэрчлэх үнэлгээг ижил кодоор өөр зорилгоор (жишээ нь: ISO 13485, ISO 3834, EN 9100) ойрын хугацаанд гүйцэтгэсэн бол MNAS дахин гэрчлэх ажиллагаа явуулах хэрэгтэй эсэхийг авч үзнэ.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 26/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

Хамрах хүрээний бүлэг

Техникийн бүлэг		ОУИФ код	IAF ID 1-д заасан эдийн засгийн сектор/үйл ажиллагааны тайлбар	Шийдвэр-лэх код
БҮЛЭГ 1	ХАА, ойн аж ахуй, загасны аж ахуй	1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй	1
БҮЛЭГ 2	Хүнс	3	Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тамхи	3
		30	Зочид буудал, рестарон	
БҮЛЭГ 3	Механик	17	“Метал бүтээгдэхүүн”-ээр хязгаарлагдсан	20 эсвэл 21
		18	Машин, тоног төхөөрөмж	
		19	Цахилгаан ба оптик тоног төхөөрөмж	
		20	Хөлөг онгоц үйлдвэрлэл	
		21	Нисэх	
		22	Бусад тээвэрлэх төхөөрөмж	
БҮЛЭГ 4	Цаас	7	“Цаасан бүтээгдэхүүн”-ээр хязгаарлагдсан	9
		8	Нийтлэлийн компани	
		9	Хэвлэлийн компани	
БҮЛЭГ 5	Барилга байгууламж	28	Барилга байгууламж	28
		34	Инженерчлэлийн үйлчилгээ	
БҮЛЭГ 6	Бараа үйлдвэрлэл	4	Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн	[4 (будах) ба 5 (идээлэх)] эсвэл 6
		5	Савхи, савхин бүтээгдэхүүн	
		6	Мод, модон бүтээгдэхүүн	
		23	Аль ч ангилалд багтахгүй үйлдвэрлэл	
БҮЛЭГ 7	Химийн бодис	7	“Ислэг ба цаас үйлдвэрлэл”-ээр хязгаарлагдсан	[7 ба 10 ба 12 ба 13 ба 16] эсвэл 17
		10	Кокс ба сайжруулсан газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл	
		12	Химийн бодис, химийн бүтээгдэхүүн, утас	
		13	Эм бэлдмэл	
		14	Резин, хуванцар бүтээгдэхүүн	
		15	Метал бус эрдсийн бүтээгдэхүүн	
		16	Бетон, цемент, шохой, гипс г.м	
		17	“Үндсэн метал бүтээгдэхүүн”-ээр хязгаарлагдсан	
БҮЛЭГ 8	Уурхай ба олборлолт	2	Уурхай ба олборлолт	2
БҮЛЭГ 9	Хангамж	25	Цахилгаан хангамж	25 эсвэл 26
		26	Хийн хангамж	
		27	Усан хангамж	
БҮЛЭГ 10	Тээвэрлэлт, Хаягдлын менежмент	31	Тээвэрлэлт, агуулах, харилцаа холбоо	[31 (аюултай бүтээгдэхүүнээр хязгаарлагдсан) ба 24] эсвэл 39 (NACE 37, 38.1, 38.2, 39-өөр хязгаарлагдсан)
		24	Дахин боловсруулах	
		39	Бусад нийгмийн үйлчилгээ	
БҮЛЭГ 11	Үйлчилгээ	29	Бөөний ба жижиглэн худалдаа; Моторт тээврийн хэрэгслийн,	29 эсвэл 35 эсвэл 36

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо:24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 27/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

			мотоцикл ба хувийн болон гэр ахуйн барааны засвар	
		32	Санхүүгийн зуулчлал, үл хөдлөх хөрөнгө, түрээс	
		33	Мэдээллийн технологи	
		35	Бусад үйлчилгээ	
		36	Төрийн захиргаа	
		37	Боловсрол	
БҮЛЭГ 12	Цөмийн	11	Цөмийн түлш	11
БҮЛЭГ 13	Эрүүл мэнд	38	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	38

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 28/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

ХАВСРАЛТ F: МАБМТ (ISO/IEC 27001)-ны гэрчлэх үнэлгээ

1. ЗОРИЛГО:

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрийн хүрээнд гэрчлэх үнэлгээг төлөвлөх зааврыг тодорхойлоход оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү хавсралт нь Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрт хамаарна.

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 MNAS нь МАБМТ-ны итгэмжлэлийн гэрчлэх үнэлгээний хөтөлбөрийг боловсруулахдаа ямагт ISO/IEC 17021-1 болон ISO/IEC 27006-1 стандартын шаардлагад үндэслэнэ.

3.2 Гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө нь MNAS итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчдийн тоо, ББ-д ажиллаж буй буюу бүртгэлтэй аудиторуудын тоо, зах зээлээс авсан санал хүсэлт, гомдол, өмнөх үнэлгээнээс гарсан үр дүн зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. MNAS нь шаардлагатай гэж үзвэл тодорхой аудитор, эсвэл итгэмжлэгдсэн гэрчилгээтэй байгууллагын гэрчлэх үнэлгээг хийхээр сонгож болно.

3.3 Ердийн МАБМТ-ны гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө нь дараахь хүснэгтэд харуулсанаар итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчдийн тоо болон ББ-д ажиллаж буй буюу бүртгэлтэй аудиторуудын тоонд үндэслэнэ. Үүнд:

Үйлчлүүлэгчийн тооноос хамаарсан гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө

Д/д	Сүүлийн 12 сарын хугацаанд MNAS итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчийн тоо	Жилд хийх гэрчлэх үнэлгээний тоо	Тайлбар
1	1-25	1	
2	26-50	2	
3	51-100	3	
4	101-250	4	
5	251-1000	5	
6	1001 ба түүнээс дээш	6	

Дүрэм 1: Нэмж дурдахад, гэрчлэх үнэлгээ нь холбогдох IAF-ын заавал мөрдөх баримт бичиг (MDs), хэрэв байгаа бол схем эзэмшигчийн шаардлагыг хангасан байна.

Аудиторуудын тооноос хамаарсан гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 29/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

Д/д	ББ-д ажиллаж буй/бүртгэлтэй аудиторуудын тоо	Жилд гэрчлэх үнэлгээнд хамруулах аудиторуудын тоо	Тайлбар
1	1-10	2	
2	11-50	4	
3	51 ба түүнээс дээш	6	

3.4 Дээрх төлөвлөгөө нь жил бүр дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ хийх нөхцөлтэй байна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
	Өөрчлөлт No: 02	
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	
Хэвлэсэн огноо:24.06.2016	Page: 30/35	

ХАВСРАЛТ G: ЭХМТ (ISO 50001)-ны гэрчлэх үнэлгээ

1. ЗОРИЛГО:

Эрчим хүчний менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрийн хүрээнд гэрчлэх үнэлгээг төлөвлөх, итгэмжлэлийн хамрах хүрээний салбаруудыг ангилахтай холбоотой зааврыг тодорхойлоход оршино. Энд өгөгдсөн хамрах хүрээний ангилал нь мөн аудиторын чадамжийг тогтоох техникийн салбаруудыг тодорхойлох үндэс болно.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү хавсралт нь Эрчим хүчний менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрт хамаарна.

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 MNAS нь ЭХМТ-ны итгэмжлэлийн гэрчлэх үнэлгээний хөтөлбөрийг боловсруулахдаа ямагт ISO/IEC 17021-1 болон ISO 50003 стандартын шаардлагад үндэслэнэ.

3.2 MNAS нь эрчим хүчний хэрэглээ, төрөлд тулгуурлан итгэмжлэлийн хүрээг 8 техникийн чиглэлд ангилан тодорхойлсон. Эдгээр нь гэрчлэх үнэлгээгээр ажиллах салбарыг сонгох үндэс болно. Анхдагч итгэмжлэлийн үнэлгээнд өндөр төвөгшилтэй техникийн чиглэлийг сонгоно.

Техникийн чиглэл тус бүрийн төвөгшлийн талаар дараах хүснэгтэд харуулав.

Техникийн чиглэлийн эрсдэлийн түвшний ангилал

Д/д	Техникийн чиглэл		Төвөгшлийн зэрэг	Тайлбар
1	Аж үйлдвэрлэл (хөнгөн болон дунд)	A	7	
2	Аж үйлдвэрлэл (хүнд)	B	8	Хамгийн өндөр төвөгшилтэй
3	Барилга	C	5	
4	Цогцолбор барилга, хотхон	D	6	
5	Тээвэр	E	3	
6	Уул уурхай	F	2	
7	Хөдөө аж ахуй	G	1	Хамгийн бага төвөгшилтэй
8	Эрчим хүчний нийлүүлэлт	H	4	

3.3 Гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө нь MNAS итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчдийн тоо, ББ-д ажиллаж буй буюу бүртгэлтэй аудиторуудын тоо, зах зээлээс авсан санал хүсэлт, гомдол, өмнөх үнэлгээнээс гарсан үр дүн зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 31/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

хамаарна. MNAS нь шаардлагатай гэж үзвэл тодорхой аудитор, эсвэл итгэмжлэгдсэн гэрчилгээтэй байгууллагын гэрчлэх үнэлгээг хийхээр сонгож болно.

3.4 Ердийн ЭХМТ-ны гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө нь дараахь хүснэгтэд харуулсанаар итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчдийн тоо болон ББ-д ажиллаж буй буюу бүртгэлтэй аудиторуудын тоонд үндэслэнэ. Үүнд:

Үйлчлүүлэгчийн тооноос хамаарсан гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө

Д/д	Сүүлийн 12 сарын хугацаанд MNAS итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчийн тоо	Жилд хийх гэрчлэх үнэлгээний тоо	Тайлбар
1	1-25	1	
2	26-50	2	
3	51-100	3	
4	101-250	4	
5	251-1000	5	
6	1001 ба түүнээс дээш	6	

Дүрэм 1: Нэмж дурдахад, гэрчлэх үнэлгээ нь холбогдох IAF-ын заавал мөрдөх баримт бичиг (MDs), хэрэв байгаа бол схем эзэмшигчийн шаардлагыг хангасан байна.

Аудиторуудын тооноос хамаарсан гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө

Д/д	ББ-д ажиллаж буй/бүртгэлтэй аудиторуудын тоо	Жилд гэрчлэх үнэлгээнд хамруулах аудиторуудын тоо	Тайлбар
1	1-10	2	
2	11-50	4	
3	51 ба түүнээс дээш	6	

3.5 Дээрх төлөвлөгөө нь жил бүр дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ хийх нөхцөлтэй байна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 32/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

ХАВСРАЛТ Н: АЭМТ (ISO 37001)-ны гэрчлэх үнэлгээ

1. ЗОРИЛГО:

Авлигын эсрэг менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрийн хүрээнд гэрчлэх үнэлгээг төлөвлөх зааврыг тодорхойлоход оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү хавсралт нь Авлигын эсрэг менежментийн тогтолцооны итгэмжлэлийн хөтөлбөрт хамаарна.

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 MNAS нь АЭМТ-ны итгэмжлэлийн гэрчлэх үнэлгээний хөтөлбөрийг боловсруулахдаа ямагт ISO/IEC 17021-1 болон ISO/IEC TS 17021-9 стандартын шаардлагад үндэслэнэ.

3.2 Гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө нь MNAS итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчдийн тоо, ББ-д ажиллаж буй буюу бүртгэлтэй аудитуруудын тоо, зах зээлээс авсан санал хүсэлт, гомдол, өмнөх үнэлгээнээс гарсан үр дүн зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. MNAS нь шаардлагатай гэж үзвэл тодорхой аудитор, эсвэл итгэмжлэгдсэн гэрчилгээтэй байгууллагын гэрчлэх үнэлгээг хийхээр сонгож болно.

3.3 Ердийн АЭМТ-ны гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө нь дараахь хүснэгтэд харуулсанаар итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчдийн тоо болон ББ-д ажиллаж буй буюу бүртгэлтэй аудитуруудын тоонд үндэслэнэ. Үүнд:

Үйлчлүүлэгчийн тооноос хамаарсан гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө

Д/д	Сүүлийн 12 сарын хугацаанд MNAS итгэмжлэлтэй гэрчилгээ олгосон үйлчлүүлэгчийн тоо	Жилд хийх гэрчлэх үнэлгээний тоо	Тайлбар
1	1-25	1	
2	26-50	2	
3	51-100	3	
4	101-250	4	
5	251-1000	5	
6	1001 ба түүнээс дээш	6	

Дүрэм 1: Нэмж дурдахад, гэрчлэх үнэлгээ нь холбогдох IAF-ын заавал мөрдөх баримт бичиг (MDs), хэрэв байгаа бол схем эзэмшигчийн шаардлагыг хангасан байна.

Аудитуруудын тооноос хамаарсан гэрчлэх үнэлгээний төлөвлөгөө

Д/д	ББ-д ажиллаж буй/бүртгэлтэй аудитуруудын тоо	Жилд гэрчлэх үнэлгээнд хамруулах аудитуруудын тоо	Тайлбар
-----	--	---	---------

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 33/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	

1	1-10	2	
2	11-50	4	
3	51 ба түүнээс дээш	6	

3.4 Дээрх төлөвлөгөө нь жил бүр дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ хийх нөхцөлтэй байна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
	Өөрчлөлт No: 02	
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	
Хэвлэсэн огноо:24.06.2016		Page: 34/35

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

<u>Өөрчлөлт No.</u>	<u>Огноо</u>	<u>Баталсан</u>	<u>Хуудасны дугаар</u>	<u>Оруулсан өөрчлөлт</u>
01	18.02.2025	MNAS дарга	Бүх хуудас	~ Баримт бичгийн агуулгыг сайжруулсан. ~ MNAS AG 07, 08 баримт бичгүүдийг нэгтгэсэн. ~ ОУИФ-ын 2023, 2024 онд батлагдсан заавал мөрдөх баримт бичгүүдэд нийцүүлсэн.
02	09.07.2025	MNAS дарга	31-34	Эрчим хүчний менежментийн тогтолцоо (ISO 50001)-ны гэрчлэх үнэлгээний Хавсралт G болон Авлигын эсрэг менежментийн тогтолцоо (ISO 37001)-ны гэрчлэх үнэлгээний Хавсралт Н-г нэмсэн.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS AG07	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 02	Page: 35/35
	Өөрчлөлтийн огноо: 09.07.2025	